



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2023 оны 12 сарын 15 өдөр

Дугаар А/832

Булган сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны XII хуралдааны “Булган аймгийн 2023 оны төсөв батлах тухай” XII/21 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын 2023 оны А/593 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Булган аймгийн хэмжээнд зохион байгуулсан “Шилдэг эрх зүйн баг” шалгаруулах уралдаанд эхний 5 байрт шалгарсан Дашинчилэн, Булган, Баяннуур, Хутаг-Өндөр, Хангал сумын эрх зүйн багийг өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнасугай.

2. Булган, Баяннуур, Хангал сумын мөнгөн шагнал, 5 багийн өргөмжлөл хийлгэх зардал 1,400,000 (нэг сая дөрвөн зуун мянга) төгрөгийг “Бүх нийтийн эрх зүйн боловсрол”, “Зөв дадал архигүй орчин” хөтөлбөрөөс гаргасугай.

3.Хууль, эрх зүйн мэдээллийг иргэдэд тасралтгүй хүргэх зорилгоор подкаст бэлтгэхэд зориулан “Бүх нийтийн эрх зүйн боловсрол”, “Зөв дадал архигүй орчин” хөтөлбөрөөс 3,410,000 (Гурван сая дөрвөн зуун арван мянга) төгрөгийг зарцуулсугай.

4.Шаардагдах хөрөнгийг хөтөлбөрийн зардлаас санхүүжүүлэхийг Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Алтаншагай)-д зөвшөөрсүгэй.



ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ

6323011002

Аймгийн Засаг даргын 2023 оны  
12 дугаар сарын 15-ны өдрийн А/БЗЗ  
захирамжийн 1 дүгээр хавсралт

“Шилдэг эрх зүйн баг”-аар шалгарсан 5 багийн шагналын сан

Д/д	Сум	Байр	Шагналын сан	Хаанаас
1	Дашинчилэн	1	800,000	АИТХ
2	Булган	2	600,000	АЗДТГ
3	Баяннуур	3	400,000	АЗДТГ
4	Хангал	4	200,000	АЗДТГ
5	Хутаг-Өндөр	5	200,000	АИТХ

“Бүх нийтийн эрх зүйн боловсрол” “Зөв дадал архигүй орчин” хөтөлбөрөөс гарах  
мөнгөн дүнгийн зарцуулалт

Д/д	Зарцуулалт	Мөнгөн дүн
1	Булган сумын шагнал (2-р байр)	600,000
2	Баяннуур сумын шагнал (3-р байр)	400,000
3	Хангал сумын шагнал (4-р байр)	200,000
4	Шилдэг эрх зүйн багаар шалгарсан 5 багийн жаазтай өргөмжлөл хийлгэх	40,000x5=200,000
5	Подкаст хийлгэх зардал	3,410,000
	Нийт	4,810,000